

БАТЛАВ: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.АРТАГ



Даатгалын үйлчилгээ авах ажлын даалгавар

Үндэслэл:

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутагт байрлах “Тавантолгой” ХК-ийн бүртгэлтэй эд хөрөнгө, хүнд машин механизм, тээврийн хэрэгсэл, ажиллагсдыг байгаль орчин, гэнэтийн болон гадны хүчин зүйлээс гарч болзошгүй эрсдлээс хамгаалах, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, эрсдэлийг бууруулах, гарч болзошгүй хохирлыг нөхөн төлөх санхүүгийн эх үүсвэрийг баталгаажуулах даатгалын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагаас үйлчилгээ авах.

	Ерөнхий мэдээлэл
Захиалагч:	“Тавантолгой” ХК
Захиалагчийн хаяг:	Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Цагаан-Овоо баг, Компанийн төв байр
Даатгалын төрөл:	<ol style="list-style-type: none">1. Ажиллагсадын гэнэтийн ослын даатгал2. Эд хөрөнгийн даатгал3. Хүнд машин механизм, тээврийн хэрэгсэлийн даатгал4. Жолоочийн хариуцлагын даатгал
Ерөнхий гүйцэтгэх ажлын цар хүрээ дурдсан эрсдлээс даатгана:	<p>1. <u>Ажиллагсадын гэнэтийн ослын даатгал</u></p> <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 3.1.7, 3.1.20-д заасан ослын эрсдлүүд, Гэнэтийн ослын улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын зэрэглэл тогтоолголт, нас баралт</p> <ul style="list-style-type: none">• Гадны нөлөөллийн эрсдэл /бусдын гэмт үйлдлийн улмаас сум, хутга, мэсэнд өртөх, хорлогдох, зодуулах, цохиулах зэргээр гэмтэх/• Ахуйн эрсдэл /даатгуулагчийн амьдардаг орон сууц, гэр, зуслан, хувийн болон нийтийн байр зэрэг ахуйн орчинд тохиолдож болох гэнэтийн ослоуд хамаарна ба унаж бэртэх, хальтрах, зам тээврийн аюул осолд өртөх, элдэв зүйлд цохиулах, хавчуулах, түлэгдэх, хорт хий, химийн бодисонд хордох зэрэг/• Байгалийн хүчин зүйлээс шалгаалсан эрсдэл /хуй салхи, цасан болон шороон шуурга, үер, аянга цахилгаан, аадар бороо, мөндөр, газар хөдлөлт зэрэг бусад байгалийн бүх төрлийн эрсдлүүд/• Зам тээврийн хөдөлгөөнд оролцох үеийн эрсдэл /Замын гарц гарам болон замын хажуугийн явган хүний зам дээр явж байх үеийн осол, Автомашин, мотоцикл, унадаг дугуй зэрэг техник хэрэгслээр зорчих явцад тээврийн хэрэгсэл мөргөлдөх, онхолдох зэрэг осол багтана/• Даатгуулагч ажилтны эрүүл мэндэд ямар нэгэн хохирол учирсан, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийн дагуу ослын акт үйлдэгдсэн тохиолдол бүрд нөхөн төлбөр заавал олгогдоно• Гэрээ байгуулснаас хойш даатгуулагч ажилтан халагдсан, ажлын байр өөрчлөгдсөн тохиолдолд захиалагчийн хүсэлтээр даатгалын гэрээний ажилтны нэрс бүхий хавсралтад тухай бүрд нь өөрчлөлт оруулж байх болно.

- Цахим и-мэйлээр шинэчилсэн нэрсийг улирал бүр хоёр тал харилцан баталгаажуулж болно.
- Гэнэтийн ослын даатгалд хамрагдах ажиллагсдын нэрсийн жагсаалтыг гэрээний хавсралтаар батална.

2. Эд хөрөнгийн Сдаатгал

Компанийн эд хөрөнгийг байгалийн болон галын, сантехникийн, цахилгааны болон бусад гадны нөлөөнөөс шалтгаалсан эрсдлээс хамгаалах, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, эрсдэлийг бууруулах, гарч болзошгүй хохирлыг нөхөн төлөх санхүүгийн эх үүсвэрийг баталгаажуулах

- Байгалийн эрсдэл /Бороо, цас, мөндөр, шуурга, үер, ой хээрийн түймэр, аянга, цахилгаан, газар хөдлөлт зэрэг байгалийн эрсдэлийн улмаас учирсан хохирол/
- Галын болон тэсрэлт, дэлбэрэлтийн эрсдэл / Гал, түймэр, шаталт, ноцолт, тэсрэлт, дэлбэрэлтийн улмаас учирсан хохирол /
- Сантехникийн эрсдэл / Сантехникийн ил, далд шугам сүлжээ, холбогдсон эд ангийн гэмтэл, хөдлөлт, техникийн доголдол болон усны хэвийн биш буюу хэт өндөр даралтаас үүдэн учирсан хохирол/
- Цахилгааны эрсдэл /Цахилгааны өндөр хүчдэл, хэвийн биш эсхүл хэт хэлбэлзэл, цахилгаан шитний гэмтэл, гал хамгаалагч, хуваарилагч, тусгаарлагчийн гэмтэл эсхүл доголдол, цахилгаан гүйдлийн шууд бус нөлөөллөөс үүдэлтэй учирсан хохирол/
- Эд хөрөнгийн даатгалд хамрагдах хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар илгээнэ.
- Гэрээ байгуулснаас хойш даатгуулсан эх хөрөнгө хасагдсан, нэмэгдсэн, өөрчлөгдсөн тохиолдолд захиалагчийн хүсэлтээр даатгалын гэрээний хавсралтад тухай бүрд нь өөрчлөлт оруулж болно.

3. Хүнд машин механизм, тээврийн хэрэгсэлийн даатгал

Компанийн хөрөнгөд бүртгэлтэй хүнд машин механизм, тээврийн хэрэгсэлүүдэд учирч болзошгүй эрсдлээс хамгаалах, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, эрсдэлийг бууруулах, гарч болзошгүй хохирлыг нөхөн төлөх санхүүгийн эх үүсвэрийг баталгаажуулах


- Хөдөлгөөнд оролцох үеийн эрсдэл / Зам тээврийн осол, онхолдох, хоорондоо мөргөлдөх, биет зүйл мөргөх, шарваж гулсах, элдэв биет зүйл цохиулах, ухрах, зогсох, байрлуулах, үйлдэл хийх үед учрах хохирол/
- Автограж, зогсоол, талбайд хадгалагдах үеийн гадны нөлөөтэй бүх төрлийн эрсдэл /барилга байгууламж болон биет зүйлс унах, нурах, галын эрсдэл, химийн хорт бодисын нөлөө, гадны нөлөөтэй элдэв биет зүйлээр цохих, зурах, гуравдагч этгээдийн санамсаргүй болон санаатай үйлдлээс шалтгаалан учирсан хохирол/
- Байгалийн эрсдэл / хуй салхи, цасан болон шороон шуурга,

	<p>үер, аянга цахилгаан, аадар бороо, мөндөр, газар хөдлөлт, хөрс нурулт, цөмрөлт зэрэг бусад байгалийн бүх төрлийн эрсдлүүд/</p> <ul style="list-style-type: none"> • Гуравдагч этгээдээс учруулах эрсдэл /хулгай, дээрэм, хорлон сүйтгэх ажиллагаа, түүнээс үүдсэн эрсдэл, зөөн тээвэрлэх үеийн эрсдэл, дугуйнаас үүдэн гарах эрсдэл, засвартай байх үеийн эрсдэл, жолоо шилжүүлэх үеийн эрсдэл, мал амьтнаас учруулах эрсдэл, замын нөхцөл байдал, бусад тээврийн хэрэгсэлээс чулуу үсрэх зэргээс шалгаалсан эрсдэл/ • Гэрээ байгуулснаас хойш даатгуулсан хүнд машин механизм, тээврийн хэрэгсэлүүд хасагдсан, нэмэгдсэн, өөрчлөгдсөн тохиолдолд захиалагчийн хүсэлтээр даатгалын гэрээний хавсралтад тухай бүрд нь өөрчлөлт оруулж болно. <p>Жич: Тээврийн хэрэгсэлийн засвар үйлчилгээг албан ёсны дистрибьютер компанийн үнийн саналыг удирдгал болгож нөхөн төлбөрийн хэмжээг тогтооно.</p> <p>4. <u>Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал</u></p> <p>Жолоочийн даатгалын тухай хуульд заасны дагуу жолоочийг хариуцлагын албан журмын даатгалд хамруулах, зам, тээврийн ослын улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хохирогчийн эрхийг хамгаалахтай холбоотой даатгал</p> <ul style="list-style-type: none"> • Монгол Улсын нутаг дэвсгэрт болон хилийн завсрын бүс болох Цагаан хад, Гашуун сухайт мөн БНХАУ-ны хилийн Ганц модны боомтын нутаг дэвсгэрт даатгалд хамруулна. • Жолооч нь автотээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдад учруулсан дараах хохирлыг 100% нөхөн төлнө. <ul style="list-style-type: none"> - Амь насанд хохирол учруулах - Эрүүл мэндэд хохирол учруулах - Эд хөрөнгөнд хохирол учруулах
<p>Бусад шаардлага:</p>	<ul style="list-style-type: none"> • Даатгалын гэрээ нь давхар даатгалын ерөнхий гэрээнд хамгаалагдах нөхцөлөөр хангасан байх; • Дараах төрлийн эрсдэлийг давхар даатгалд хамруулсан байх <ul style="list-style-type: none"> - Барилга, үл хөдлөх болон хөрөнгийн даатгал - Техник, тоног төхөөрөмжийн даатгал • Давхар даатгагчтай хамтран ажиллаж буйг нотлох баримт бичиг Үүнд: Давхар даатгагчийн товч танилцуулга, Давхар даатгалын хамтран ажиллах гэрээ; • Тендерт оролцогч нь даатгалын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, хугацаанаас өмнө дуусгавар болгох тохиолдолд хураамжийг хэрхэн тооцох талаар аргачлалыг тодорхой ирүүлэх; • Гэрээний төсөлд даатгагч хохирлыг нөхөн төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн дүнгээс хоног тутамд 0.5 хувьтай тэнцэх алдангийг тооцож төлөх; • Даатгалын хугацаанд даатгуулагч нөхөн төлбөр авсан тохиолдолд тухайн жилийн даатгалын үнэлгээ нь гэрээний үлдэх хугацаанд нөхөн төлбөр авсан хэмжээгээр буурах бөгөөд зохих хураамжийг төлсний үндсэн дээр даатгалын үнэлгээг дахин сэргээх нөхцөлийг хүлээн зөвшөөрөх; • Гэрээ байгуулах үеийн хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь даатгуулсан

	<p>үнэлгээнээс 10 хүртэл хувиар өссөн бол хувь тэнцүүлэхгүй, харин 10 буюу түүнээс дээш хувиар өссөн тохиолдолд түүнийг зах зээлийн үнэлгээнд эзлэх хувь хэмжээгээр хувь тэнцүүлэн нөхөн төлбөрийг олгох;</p> <ul style="list-style-type: none"> • Даатгуулагч даатгуулах зүйлээс худалдан авалт хийгээгүй, даатгуулсан зүйлийн тоог цөөрүүлж болох бөгөөд энэ тохиолдолд даатгалын хураамжийг даатгуулчид суутган тооцуулах; • Гэрээнд талууд эрх тэгш байх зарчмын үндсэн дээр талуудын эрх үүрэг, гэрээний нууцлал, хариуцлага, маргаан шийдвэрлэх заалт зэргийг тодорхой тусгана
--	--

Боловсруулсан:

ХАХХэлтсийн захирал



Ч.Төрмандах

ХОТСХэлтсийн захирал



С.Энхбаяр

ХАБЭАБО-ны хэлтсийн захирал

Б.Содномцэрэн

Гэрээ, эрхзүйн албаны дарга

Б.Батсүрэн